



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/21

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Монос маркет эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар шинээр олгосугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв, Үенч, Дөргөн сумдын Эрүүл мэндийн төв, Дарви эргэлтийн эмийн сан, Азифарма, Монос эм ханган нийлүүлэх байгууллага, Ара дент шүдний эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн эмнэлэг, Хан хөхийн эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жил хүртэлх хугацаагаар тус тус сунгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг хангасан нь Эрүүл мэндийн чиглэлээрх тусгай зөвшөөрлийн комиссын саналаар зөвшөөрөгдсөн мэс засал, гэмтэл, хавдар, дотор, уламжлалт, дүрс оношилгоо, лабораторийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Ач заяа” эмнэлэгт амбулаторийн тусламж үйлчилгээний, шүдний эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Сувдан шигтгээ” эмнэлэгт согог засал чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг нэмж, Уламжлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Ивээл эмнэлгийн дотрын дүрс оношилгооны чиглэлийг хасах өөрчлөлтийг оруулсугай.

8400 01 0137


D/Zah-A/21-Bo

4. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл шаардлагыг хангаагүй ахуй шавж, мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ноён худаг” нөхөрлөлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зарсан Мөнхбаян булган эмийн сан, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах хүний нөөцгүй Үенч сумын эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааг цуцалсугай.

6. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан, сунгуулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан, түдгэлзүүлсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ